



МОНГОЛ УЛСЫН
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ
САЙДЫН ТУШААЛ

2006 оны 03 сарын 13 өдөр

Дугаар 71

Улаанбаатар хот

Гадаадад суралцуулах тухай

"Өндөр хөгжилтэй орны их сургуульд Засгийн газрын тэтгэлгээр хүн суралцуулах асуудлыг зохицуулах зөвлөл"-ийн 2006 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн хурлын тэмдэглэл, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Санхүү, эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын 2,6-г үндэслэн ТУШААХ нь:

1. Чинтөгс овогтой Чинцолмонг ОХУ-ын Москва хотын Харилцаа холбооны дээд сургуульд 2 жилийн хугацаагаар, Алтанцэцэг овогтой Наранчимэгийг БНХАУ-ын Хайнаны их сургуульд олон улсын худалдаа, эдийн засгийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Түмэндэмбэрэл овогтой Энэрэлийг Англи улсын Кардиффийн их сургуульд санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Намсрайжав овогтой Батхишигийг Англи улсын Брэдфордын их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 1 жилийн хугацаагаар, Ёндон овогтой Пүрэвдуламыг АНУ-ын Калифорнийн Фридрих Тэйлорын их сургуулийн магистрантурт бизнесийн удирдлагын чиглэлээр 1 жилийн хугацаагаар, Бямбажав овогтой Ганбатыг Англи улсын Вильямс коллежийн магистрантурт хууль зүйн чиглэлээр 1 жилийн хугацаагаар, Моонон овогтой Сумъяадоржийг АНУ-ын Регис их сургуулийн магистрантурт санхүү, нягтлан бодох бүртгэлийн чиглэлээр 2 жилийн хугацаагаар, Дашхүү овогтой Одонцэцэгийг ХБНГУ-ын Детмондын дээд сургуулийн докторантурт 3 жилийн хугацаагаар тус тус 2005-2006 оны хичээлийн жилээс суралцуулсугай.


2. АНУ-ын Блюмингтон хотын Индианагийн их сургуульд судалгааны ажил эрхэлж буй Лувсанноров овогтой Эрдэнэчимэг, Англи улсын Грей Кенсер дээд сургуулийн магистрантурт радиологийн чиглэлээр суралцаж буй Минжгээ овогтой Минжмаа, АНУ-ын Денвер хот дахь Колорадогийн их сургуулийн магистрантурт байгаль орчны бохирдол, шинжилгээний чиглэлээр суралцаж буй Ганжууржав овогтой Эрдэнэбаясгалан нарын суралцах хугацааг тус бүр 1 жилээр сунгасугай.

3. ОХУ-ын Москва хотын К.А.Тимирязевын нэрэмжит Хөдөө аж ахуйн академийн аспирантурт суралцаж буй Товуудорж овогтой Батсүх, ОХУ-ын Санкт-Петербург хотын Технологи, дизайны их сургуулийн аспирантурт суралцаж буй Зууннасан овогтой Алтанзагас, ОХУ-ын Санкт-Петербург хотын А.И.Герцений нэрэмжит Улсын багшийн их сургуулийн аспирантурт суралцаж

3000012

буй Баярмагнай овогтой Мөнхзаяа нарын эрдэм шинжилгээний ажлын хамгаалалтын зардлыг тус тус зээлээр олгосугай.

4. Боловсрол, Соёл, Шинжлэх ухааны сайд, Санхүү, Эдийн засгийн сайдын 2001 оны 310/290 дүгээр хамтарсан тушаалаар батлагдсан "Өндөр хөгжилтэй оронд магистрантур, аспирантур, докторантурт суралцагчдын зардлыг санхүүжүүлэх журам"-ын дагуу суралцагчидтай гэрээ байгуулж, холбогдох төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Боловсролын газрын Мэргэжлийн боловсролын хэлтэс /Д.Баяр/-т тус тус даалгасугай.



Ө.Энхтүвшин

Ө.ЭНХТҮВШИН